



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 32

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын Номгон ахлах сургуулийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад 138,0 мянган төгрөгийн номыг шууд зардлаар хүлээн зөвшөөрч, хөрөнгөд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2 дахь "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ." гэсэн заалтыг зөрчсөн байна.






Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй;" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй 138,0 /Нэг зуун гучин найман мянга/ төгрөгийн номыг хөрөнгөд орлогоор бүртгэх.

2518023

2. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Номгон ахлах сургуулийн захирал Л.Сарангэрэл, нягтлан бодогч Г.Баатартогтох нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

<p>БИЧСЭН:</p> <p>АУДИТОР  П.МӨНХ-ЭРДЭНЭ</p>  <p>6417143544 БЧОА0067 0007423</p>	<p>ЗӨВШӨӨРСӨН:</p> <p>НОМГОН АХЛАХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  Л.САРАНГЭРЭЛ</p> <p>НЯГТЛАН БОДОГЧ  Г.БААТАРТОГТОХ</p>  <p>БИОД0012</p>
--	---

D:\Munkherdene_2018\Alban Shaardlaga_2018\АШ-Номгон Сургууль.Docx

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.